

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛИМПТИЙН ХОРОО,
УЛААНБААТАР ХОТЫН АХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАМТАРСАН ХУРЛЫН ТОГТООЛ

1990 оны 12 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 54/297 Улаанбаатар
хот

Районы биеийн тамир, спортын
хороо байгуулах тухай

Хөнгөн хүнсний аж үйлдвэрийн салбарын зохион байгуулал-
танд өөрчлөлт орж биеийн тамир спортын "Хөдөлмөр" нийгэмлэгийн
бага хурлаас гаргасан шийдвэрийг үндэслэн Монголын үндэсний
олимпийн хороо, Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны
хамтарсан хурлаас ТОГТООХ нь:

1.Биеийн тамир спортын "Хөдөлмөр" нийгэмлэгийг татан буул-
гаж Ажилчины районы биеийн тамир, спортын хороог байгуулсугай.

2.Дэвсгэрийн нийт байгууллагын ажилчин, албан хаагчид,
хүүхэд залуучуудын дунд зохиох биеийн тамир спортын ажлыг улам
эрчимжүүлж, материаллаг баазыг бэхжүүлэн, хөрөнгө хүчийг төв-
лөрүүлэн ажиллахыг Ажилчины районы АХ-ын гүйцэтгэх захиргаа
/Д.Ойдовсамбуу/-д даалгасугай.

3.Биеийн тамир спортын "Хөдөлмөр" нийгэмлэгт ашиглагдаж
байсан үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг Ажилчины районы
биеийн тамир спортын хороонд балансаас балансад шилжүүлэн,
биеийн тамир спортын хорооны арга хэмжээний зардлыг Улаанбаатар
хотын жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусган санхүүжүүлж байхыг
Хотын санхүүгийн газар /Д.Гонгор/, биеийн тамир спортын хороо
/Д.Содномзундуй нарт үүрэг болгосугай.



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛИМПТИЙН
ХОРООНЫ ДАРГА

С.БОЛД

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

Л.ЭНЭБИШ